

**“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 03-р сарын 14-ний өдөр

№ 7/19

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан
Хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1, 62.1.1 болон 62.1.7 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Баянгол зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04-р сарын 25-ний өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Баянгол зочид буудлын Рестораны зааланд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1 Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах
 - 2.3 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний үндэслэлийг танилцуулах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 4 сарын 05-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо МХБ-д хүргүүлэх өдрийг 2019 оны 03 дугаар сарын 15-ний өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2019 оны 03 дугаар сарын 18; 2019 оны 4 дүгээр сарын 02-ны өдрүүд байхаар тогтоосугай.
5. Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хүргүүлэх, 2019 оны 03 дугаар сарын 18 болон 4 дүгээр сарын 02-ны өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Дараах бичиг баримтыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.

6.1.Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийн хуулбар;

6.2.Хурлын санал хураах хуудас;

6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;

6.4.Хурлын зар.

7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү Тогтоолын Хавсралт №1-ээр хурлын дэгийг Хавсралт №2-оор тус тус баталсугай.

8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2019 оны 4 дүгээр 25-ны өдрийн 15 цагаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалахыг ТУЗ-ийн дарга /Б.Аюуш/-д даалгасугай.

10. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

Дарга: Т.Дөлгөөн

Гишүүд: Х.Отгонбаяр

Д.Самданжамц

Хувьцаа эзэмшигч/ Заалнаас сонгох/

11. Хурал зохион байгуулах комиссын даргаар Д.Цэнддорж-/ ТУЗ-ийн гишүүн/

Хурал зохион байгуулах комиссын нарийн бичгийн даргаар Т.Бичигмаа / СХА-ны ахлах менежер/ нарыг тус тус томилсугай

12. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /Д.Цэнддорж/-д даалгасугай.

ДАРГА

